



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 6/54

Хэрлэн сум

**А.Алтантуяад буцалтгүй
тусламж олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, аймгийн Засаг даргын Тамгын газрын "Дотоод журам"-ын 7 дугаар зүйлийн 7.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Хууль, эрх зүйн хэлтсийн дэргэдэх Архивын тасгийн Цахим сангийн ажилтан А.Алтантуяагийн гаргасан өргөдлийн дагуу нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор 80,000 (наян мянга) төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Буцалтгүй тусламжид шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын тэтгэмж, урамшууллын зардлаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНБААТАР